

УДК 930.85(517+510)

ЖАНГАР ТУУЛИЙГ СОЁЛЫН ИННОВАЦИЙН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛГОН ХӨГЖҮҮЛЖ БУЙ ОХУ-ЫН ХАЛИМАГ ТАНГАЧИЙН ТУРШЛАГА, СУРГАМЖ

Дашзэвэгийн Өрнөхдэлгэр

хэл бичгийн ухааны доктор, профессор

МУИС, Баруун бүсийн сургууль, Ховд, Монгол Улс

E-mail: urnukhdelger@num.edu.mn

Баяндалайн Бадарч

МУИС-ийн Баруун бүсийн сургуулийн докторант

Ховд, Монгол Улс

E-mail: 23D1NUM0197@stud.num.edu.mn

Хураангуй

Энэхүү өгүүлэлд Жангар туулийг соёлын инновацийн бүтээгдэхүүн болгон хадгалах, хөгжүүлэх, түгээх Халимаг (ОХУ)-ын туршлагыг судалсан болно. Жангар тууль нь Монгол үндэстний аман ардын уран зохиолын өвөрмөц дурсгал бөгөөд Халимаг, Монгол, Хятадын Ойрадуудын дунд хадгалагдан үлдсэн юм. Даяаршил, соёлын нэгдлийн нөхцөлд үндэсний хэл, соёлоо хадгалах асуудал онцгой ач холбогдолтой болж байна. Халимагийн туршлага нь төрийн бодлого, туульч бэлтгэх орчин үеийн арга барил, боловсролын системд нэгтгэх, дижитал технологи ашиглах, соёлын аялал жуулчлал хөгжүүлэх, олон улсын хамтын ажиллагаа зэргээр дамжуулан туульсын өвийг орчин үеийн соёлын идэвхтэй элемент болгон хувиргах үр дүнтэй загварыг харуулж байна. Өгүүлэлд Халимагийн соёлын бодлогын үндсэн чиглэл, орчин үеийн жангарчдын сургалтын тогтолцоо, туулийн дүрслэх урлаг, тайзны бүтээл дэх тусгал, олон улсын Жангар судлал дахь Халимагийн байр суурийг шинжилсэн. Энэхүү дүн шинжилгээнд үндэслэн Монгол Улс болон туульсын өвийг хадгалж буй бусад бүс нутагт хэрэгжүүлэх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан болно.

Түлхүүр үгс

Жангар тууль, Халимаг, соёлын инновац, биет бус соёлын өв, жангарч.

UDC 930.85(517+510)

RUSSIAN KALMYKIA'S EXPERIENCE AND LESSONS IN THE DEVELOPMENT OF THE JANGAR EPIC AS A CULTURAL INNOVATION PRODUCT

Urnukhdelger Dashzeveg

Doctor of Linguistics, Professor

NUM, Western Regional School, Khovd, Mongolia

E-mail: urnukhdelger@num.edu.mn

Bayandalayn Badarch

PhD student,

NUM, Western Regional School, Khovd, Mongolia

E-mail: 23d1num0197@stud.num.edu.mn

Annotation

This article examines the experience of the Republic of Kalmykia (Russian Federation) in preserving, developing, and promoting the Jangar epic as a cultural innovation product. The Jangar epic is a unique monument of oral folklore of the Mongolian peoples, which has been preserved among the Kalmyks, Mongols, and Oirats of China. In the context of globalization and cultural unification, the issue of preserving national languages and cultures is becoming particularly relevant. Kalmykia's experience demonstrates an effective model for transforming an epic heritage into an active element of modern culture through state policy, modern methods of training storytellers, integration into education, use of digital technologies, development of cultural tourism, and international cooperation. The article analyzes the main directions of Kalmykia's cultural policy, the system of training modern jangarchi, the reflection of the epic in visual arts and stage works, and the place of Kalmykia in international Jangar studies. Based on this analysis, conclusions and recommendations are formulated for Mongolia and other regions where the epic heritage is preserved.

Key words

Jangar epic, Kalmykia, cultural innovation, intangible cultural heritage, jangarchi.

О Р Ш И Л

Монгол угсаатны түүх, соёл, ахуй амьдралыг шингээсэн Жангар тууль нь дэлхийн ардын аман зохиолын гайхамшигт дурсгал юм. Тус тууль Халимаг (ОХУ), Монгол Улс, Хятадын Шинжаан мужийн Ойрадуудын дунд хадгалагдан үлдэж, уламжлагдан хадгалагдаж ирсэн бөгөөд тус бүр өөрийн гэсэн онцлог хувилбартай болжээ. XXI зуунд даяаршил, соёлын нэг хэвшил өрнөж буй эрин үед үндэсний хэл, соёлоо хадгалж, хөгжүүлэх асуудал олон үндэстэн угсаатны хувьд тулгамдсан асуудал болоод байна.

Халимаг улс нь Жангар туулийг хадгалах, хөгжүүлэх чиглэлээр бусдад үлгэр жишээ болохуйц туршлага хуримтлуулсан. Зөвлөлт (ЗХУ)-ийн дараах үед Халимагийн засаг захиргааны байгууллагууд түүх, соёлын өвийг хадгалах бодлогыг онцгой анхаарч эхэлсэн (Бадмаева, 2018). Энэхүү бодлогын хүрээнд Жангар тууль, жангарчдын урлагийг дэмжих олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Энэхүү өгүүлэлд Жангар туулийг соёлын инновацийн бүтээгдэхүүн болгон хөгжүүлж буй Халимаг улсын туршлагад дүн шинжилгээ хийж, үндэсний соёлын өвийг орчин үеийн нөхцөлд хэрхэн хадгалж, түгээх арга замыг тодорхойлохыг зорив. Судалгааны үр дүнд Монгол Улс, Буриад, Тува, Хятадын Ойрад зэрэг монгол угсаатнуудад туульсын уламжлалаа хадгалах, хөгжүүлэхэд хэрэг болохуйц санал зөвлөмж боловсруулахыг зорьсон болно. Мэдээллийн технологи болон салбар дундын хандлагын үүднээс авч үзвэл, 21-р зуунд Жангар судлалын өнөөгийн асуудлууд ба шинэ хэтийн төлөвд анхаарлаа хандуулах нь чухал юм (Omakaeva, 2019; 2025).

ЖАНГАР ТУУЛИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ БА ХАЛИМАГ ХУВИЛБАРЫН ОНЦЛОГ

Жангар тууль нь Халимагийн соёлын гол брэнд болж, тус улсын үндэсний өв уламжлалын салшгүй нэгэн хэсэг болдог (Кичиков, 1997). Халимаг хувилбар нь 26 дуулал, 40,000 гаруй мөртөөс бүрдэх бөгөөд энэхүү туульсын нэгдмэл, шүлэглэлийн төгс төгөлдөр байдал нь олон зууны турш уламжлан ирсэн жангарчдын авьяас билгийн ачаар хадгалагдан үлдсэн юм (Биткеева & Селеева, 2019).

Туулийн гол санаа нь элбэг хангалуун, үхэшгүй мөнх, сайн сайхан амьдралтай Бумбын орныг магтан дуулах, Жангар хааныг хүрээлэн зүг зүгийн хамгийн чадалтай, сайн баатрууд нэгдэж, улс орныхоо тогтвортой байдал, аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа болдог явдал юм. Тууль нь цэргийн эр зоригийг магтан дуулахаас гадна баатруудын эхнэрүүдийн буян зан чанар, залуу үеийн дайчдыг хэрхэн хүмүүжүүлж, боловсрол олгох онцлог шинжүүдийг өгүүлдэг (Бадма-Халгаева & Пичугина, 2020). Тиймээс Жангар тууль нь угсаатны сурган хүмүүжүүлэх ухаан, дидактик ач холбогдолтой эх хэрэглэгдэхүүн болдог.

ХАЛИМАГ УЛСЫН СОЁЛЫН БОДЛОГО БА ЖАНГАР ТУУЛЬ

1990-ээд оны ардчилсан шинэчлэлийн үед Халимаг залуучуудын дунд өвөг дээдсийнхээ соёлын өв, ялангуяа Жангар тууль, жангарчлах урлагийг сурах сонирхол эрс нэмэгдсэн (Сангаджиева, 2020).

Төрийн бодлогын үр дүнд Жангар туулийг сургуулиудад зааж эхэлсэн бөгөөд өнөөдөр уг тууль наадам, ардын баяр ёслол, албан ёсны арга хэмжээ, хурим найранд дуулагдах болжээ (Modern jangarchi of Kalmykia, 2025). Мөн жангарчид соёлын бодлого, наадам, уралдаан тэмцээнд идэвхтэй оролцож, хүндэт цол, шагнал хүртэж байна.

Халимагийн Бүгд Найрамдах Улсын Засгийн газраас баталсан “Жангар” туулийг хадгалах, судлах, түгээх 2021-2025 оны улсын хөтөлбөр нь энэ чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг системчлэн зохион байгуулах чухал баримт бичиг болсон (Халимагийн Засгийн газар, 2020). Тус хөтөлбөрт Жангар туулийн судалгааг өргөжүүлэх, туульчдыг бэлтгэх, олон нийтэд сурталчлах, дижитал хэлбэрт оруулах зэрэг олон чиглэлийн үйл ажиллагааг тусгасан байна.

ЖАНГАРЧИЙН ОРЧИН ҮЕИЙН СУРГАЛТЫН ТОГТОЛЦОО

Халимагт Жангарыг уламжлах хоёр үндсэн сургууль байдаг: Ээлэн Овлаан сургууль ба Шавалин Даваан сургууль. Эдгээр сургууль нь хэв маяг, урын сангаараа ялгаатай (Борлыкова, 2018). Орчин үеийн судалгаанууд жангарчдын сургалтын үйл явц, тэдний нийгэм, соёлын шинэ нөхцөлд дасан зохицох стратегийг судалж байна.

2023 оны хээрийн шинжилгээний судалгаагаар жангарчдын ур чадвар нь зөвхөн цээжлэх биш, харин текстийг дотооддоо шингээж, хувьсах чадварт оршиж байгааг харуулсан (Modern jangarchi of Kalmykia, 2025). Тэдний туулийн авьяас, билиг нь “дуучны дуудалт” (домгийн зан үйлээр хүлээн авсан бэлэг) ба “туульчийн сургалт” (туршлагатай жангарчдын удирдлага дор эсвэл ном, бичлэг ашиглан өөрөө суралцах) гэсэн хоёр өгүүлэмжийн хүрээнд илэрхийлэгддэг. Энэ нь XIX зууны уламжлалтай нийцэж байна.

Жангарчдын сургалт нь гэр бүлийн удамшил, уран сайхныг дуурайх зэрэг уламжлалт аргуудыг аудио бичлэг ашиглах, мэргэжлийн ардын аман зохиолын судалгааг ашиглах зэрэг орчин үеийн аргуудтай хослуулдаг (Дорджиева, 2021). Одоогийн Ээлэн Овла уламжлалыг дагагчид бол Владимир Каруев, Дорж Надышев, Баатр Манжиев, Олег Калыков, Олег Манкуев, Кутлан Мукобенов нар юм. Шавалин Дава уламжлалын төлөөлөгчид бол Андрей Эрдни-Горяев, Баатр Лиджи-Горяев, Дмитрий Шараев болон бусад (Modern jangarchi of Kalmykia, 2025).

ЖАНГАР ТУУЛЬ БА УРЛАГИЙН БҮТЭЭЛ

Жангар тууль нь зөвхөн аман дууллагаар үлдээд зогсохгүй дүрслэх урлагийн бүтээлүүдэд урам зориг өгсөөр ирсэн. 1990-ээд оны Халимагийн уран бүтээлчдийн “Джунгариа” холбоо нь ардын аман зохиол, түүхэн дурсамжаас урам зориг авч, угсаатны өв уламжлалаа шинэчлэн бүтээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн (Figurative Art and Epic Imagery in Kalmykia, 2023). Энэ хүрээнд зураач Гарри Рокчинскийн Жангар туульд зориулсан цуврал бүтээлүүд онцгой байр суурь эзэлдэг.

Халимагийн орчин үеийн урлаг нь Монгол, Ойрад гарал үүслийн түүхэн дурсамжийг тусгаж, угсаатны өөрийгөө таних чадварыг бүрдүүлж байна (Figurative Art and Epic Imagery in Kalmykia, 2023). Энэ нь Жангар туулийг зөвхөн аман уламжлал

хэлбэрээр хадгалаад зогсохгүй урлагийн шинэ хэлбэрүүдээр шингээж, соёлын инновацийн бүтээгдэхүүн болгон хөгжүүлж буй хандлагыг харуулж байна.

Тайзны урлалын хувьд Халимагийн театрууд Жангар туулийн сэдэвт хэд хэдэн жүжиг тавьсан. Халимагийн үндэсний театрт “Жангар” дуурийг тавьсан бол бүжгийн чуулга “Бумба орны домог” хэмээх бүжгэн жүжгийг бүтээсэн (Манжиева, 2015). Эдгээр бүтээлүүд нь туулийг орчин үеийн тайзны урлалтай хослуулсан амжилттай жишээ болдог.

ЖАНГАР ТУУЛИЙН ДИЖИТАЛ ХУВИРГАЛ

Халимаг улсад Жангар туулийг хадгалах, түгээх өөр нэг шинэлэг арга зам бол дижитал технологийг ашиглах явдал юм. ХХI зууны эхэн үеэс Халимагийн үндэсний номын сан, Халимагийн Хүмүүнлэгийн ухааны хүрээлэн зэрэг байгууллагууд Жангар туулийн гар бичмэлүүд, аудио бичлэгүүдийг дижитал хэлбэрт оруулах ажлыг эхлүүлсэн (Биткеева & Селеева, 2019). Энэхүү ажил нь туулийн эх хэрэглэгдэхүүнийг удаан хугацаанд хадгалах, судлаачдад хүртээмжтэй болгох зорилготой юм.

Түүнчлэн Жангар туулийг цахим орчинд түгээх зорилгоор тусгай вэбсайтууд, цахим сангууд бий болсон. “Джангар” портал нь туулийн бүрэн эх, орчуулга, судалгааны материалууд, аудио бичлэгүүдийг нэгтгэсэн цахим цогцолбор болж чадсан (Убушиева, 2021). Энэ нь зөвхөн Халимаг төдийгүй дэлхийн өнцөг булан бүрт байгаа судлаачид, сонирхогчид Жангартай танилцах боломжийг нээж өгсөн.

Халимагийн эрдэмтэд Жангар туулийн текстийг компьютерын программд оруулах, корпус бий болгох ажил хийж байна (Биткеева & Селеева, 2019). Энэ нь туулийн хэл зүй, шүлэглэл, сэдэв, дүрслэлийн онцлогийг шинжлэх, харьцуулах судалгаа хийх боломжийг олгож байна.

СОЁЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ДАХЬ ЖАНГАР

Халимаг улс сүүлийн жилүүдэд соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ Жангар туулийг голлох нөөц болгон ашиглаж байна (Иванов, 2022). Жил бүр зохиогддог “Жангариада” наадам нь олон зуун жуулчдыг татдаг томоохон үйл явдал болжээ. Энэхүү наадмын үеэр жангарчдын тэмцээн, туульд дүрслэгдсэн баатруудын хувцас өмсгөлтэй жагсаал, үндэсний спорт наадам зэрэг олон төрлийн арга хэмжээ зохион байгуулагддаг.

Мөн Жангар туульд дүрслэгдсэн газруудаар аялах тусгай аялалын маршрутууд бий болсон. Жишээлбэл, Бумба орон гэж таамаглагддаг газрууд, туулийн баатруудын нэрэмжит газруудаар аялах хөтөлбөрүүд нь жуулчдад туулийн агуулгатай шууд холбогдох боломжийг олгодог (Манжиева, 2023). Энэ нь Жангар туулийг соёлын эдийн засгийн идэвхтэй хүчин зүйл болгон хувиргах нэгэн жишээ юм.

Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд Халимагт Жангар туулийн дуулалтыг үзүүлэх тусгай хөтөлбөрүүд, жангарчдын мастер-класс, үндэсний хоол, хувцас, зан заншилтай танилцах боломжуудыг санал болгодог (Иванов, 2022).

ОЛОН УЛСЫН ЖАНГАР СУДЛАЛ ДАХЬ ХАЛИМАГИЙН БАЙР СУУРЬ

Жангар судлал нь XIX зууны сүүл, XX зууны эхэн үед герман, орос эрдэмтэд Ижил мөрний Халимагуудын дундаас уг туулийг нээж дэлхийд танилцуулснаар эхэлсэн. Цаашдын судалгаагаар Жангар Хятадын Шинжааны Ойрадуудын дунд түгээмэл тархсан болохыг тогтоожээ. Хожим Монголын судлаачид Жангар нь Монгол үндэстний баатарлаг тууль болохыг нотолсон.

Халимагийн эрдэмтэн Анатолий Шалхакович Кичиков нь орчин үеийн Жангар судлалын үндэслэгч, үндэсний болон олон улсын ардын аман зохиолын салбарт нэр хүндтэй эрдэмтэн болсон (Дякиева, 2017). Тэрээр хэлмэгдүүлэлт, цөллөгт амьд үлдсэн Халимаг ардын нэрт төлөөлөгчийн хувьд ард түмэндээ үйлчлэх үлгэр жишээ үзүүлсэн юм. Түүний боловсруулсан Жангар туулийн академик хэвлэл нь Жангар судлалын алтан фонд болсон.

Халимаг улс олон улсын Жангар судлалын хэд хэдэн чухал төвүүдийг байгуулсан. Халимагийн Хүмүүнлэгийн ухааны хүрээлэнгийн Жангар судлалын төв нь 1990-ээд оны сүүлээр байгуулагдсан бөгөөд эрдэмтэн А.Ш. Кичиковын нэрэмжит болсон (Кичиков, 1997). Энэ төв нь Жангар туулийн эхийг хэвлэн нийтлэх, судалгааны ажил хийх, олон улсын эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулах зэрэг өргөн хүрээний үйл ажиллагаа явуулдаг.

2023 онд Жангар туулийн анхны англи хэлний орчуулга Саглар Бугдаевагийн орчуулгаар Калифорнийн Их Сургуулийн хэвлэлээр хэвлэгдсэн нь бараг устаж үгүй болсон уламжлалын дуу хоолойг сэргээх чухал алхам болсон (Bougdaeva, 2022).

ХАЛИМАГИЙН ТУРШЛАГЫН ОНЦЛОГ, СУРГАМЖ

Халимаг улсын Жангар туулийг хадгалж, хөгжүүлж буй туршлагын хэд хэдэн онцлог шинжийг тодорхойлж болно:

- **Төрийн бодлого, дэмжлэг:** Зөвлөлтийн дараах үед Халимагт соёлын өвийг хадгалах чиглэлээр төрийн бодлого тодорхой чиглэлтэй явагдаж, Жангар туулийг тусгайлан дэмжиж байна. 2021-2025 оны улсын хөтөлбөр нь энэхүү бодлогын системтэй хэрэгжилтийг харуулж байна.

- **Соёлын бренд болгон хөгжүүлэх:** Халимаг улс Жангар туулийг үндэсний соёлын гол бренд болгон хөгжүүлсэн. Туулийн нэр, дүрс, сэдэв нь Халимагийн албан ёсны бэлгэ тэмдэг, соёлын бүтээгдэхүүн, аялал жуулчлалын маркетингид өргөн ашиглагддаг.

- **Сургуулийн боловсролд нэвтрүүлэх:** Жангар туулийг сургуулийн хөтөлбөрт оруулж, залуу үед заах нь уламжлалыг дамжуулах үр дүнтэй арга болж байна.

- **Жангарчдыг бэлтгэх орчин үеийн арга:** Уламжлалт дамжуулах арга (гэр бүлийн удамшил, уран сайхныг дуурайх)-ыг аудио бичлэг, сурах бичиг, мэргэжлийн судалгаатай хослуулсан нь орчин үеийн нөхцөлд туульч бэлтгэх үр дүнтэй загвар болж байна.

• **Дижитал технологийг өргөн ашиглах:** Жангар туулийн эх хэрэглэгдэхүүн, аудио бичлэг, судалгааны материалуудыг дижитал хэлбэрт оруулж, цахим сан байгуулсан.

• **Олон салбарын хамтын ажиллагаа:** Жангар туулийг хадгалах, хөгжүүлэх ажилд боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, аялал жуулчлал, хэвлэл мэдээлэл зэрэг олон салбарын байгууллагууд нэгдсэн системтэйгээр оролцож байна.

ДҮГНЭЛТ

Халимаг улсын Жангар туулийг хадгалж, хөгжүүлж буй туршлага нь үндэсний соёлын өвийг орчин үеийн нөхцөлд хэрхэн шинэчлэн бүтээх, түгээх талаар үнэтэй сургамж өгч байна. Төрийн дэмжлэг, боловсролын системд нэвтрүүлэх, уламжлалт ба орчин үеийн аргуудыг хослуулах, олон төрлийн хэлбэрээр түгээх зэрэг цогц арга хэмжээний үр дүнд Жангар тууль нь Халимагийн соёлын гол бренд болж, орон нутгийн, үндэсний болон дэлхийн тавцанд Халимаг үндэстний өв уламжлалыг төлөөлөх гол элемент болж байна.

Жангар тууль бол зөвхөн түүхэн дурсгал биш, харин орчин үеийн соёлын инновацийн идэвхтэй бүтээгдэхүүн болж чадна гэдгийг Халимагийн туршлага тодорхой харуулж байна. Энэхүү туршлага нь Монгол Улс, Буриад, Тува, Хятадын Ойрад зэрэг монгол угсаатан ардуудад туульсын уламжлалаа хадгалах, хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах болно.

МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ ЗӨВЛӨМЖ

Халимагийн туршлагад үндэслэн Монгол Улсад Жангар тууль болон бусад туульсыг хадгалах, хөгжүүлэх талаар дараах санал, зөвлөмжүүдийг дэвшүүлж байна.

11.1. Бодлогын түвшинд

• “Жангар туулийг хадгалах, хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” боловсруулж, батлах. Хөтөлбөр нь 5-10 жилийн хугацаатай, тодорхой зорилт, санхүүжилт, хариуцлагатай байх

• Жангарыг хөгжүүлэх төслүүдийг төсвөөс санхүүжүүлэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих

• Жангартай холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлэх

11.2. Судлал, боловсролын түвшинд

• ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн дэргэд “Жангар судлалын төв” байгуулж, туулийн эх хэрэглэгдэхүүнийг цуглуулах, судлах, хэвлэн нийтлэх, дижитал хэлбэрт оруулах ажлыг зохион байгуулах

• Бага, суурь, бүрэн дунд боловсролын хөтөлбөрт “Жангар”-ын хэсгийг оруулах. Туульсын агуулгыг түүх, газар зүй, уран зохиол, хэлний хичээлүүдтэй холбон заах аргачлал боловсруулах

• Ховд, Увс аймагт “Жангарчдыг бэлтгэх сургууль” байгуулж, туршлагатай туульчдыг урьж ажиллуулах. Халимагийн туршлагыг ашиглан уламжлалт ба орчин үеийн аргуудыг хослуулсан сургалтын тогтолцоог бий болгох

- Их, дээд сургуулийн “Утга зохиол судлал”, “Соёл судлал”-ын ахисан түвшний сургалтын төлөвлөгөөнд “Жангар судлал” хичээлийг оруулах

- Туульчдын ур чадварыг дээшлүүлэх сургалт, семинар тогтмол зохион байгуулж, туульчдыг дэмжих төрийн бодлого баримтлах (тэтгэлэг, шагнал, цол олгох)

11.3. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн түвшинд

- Ховдод Жангарын музей байгуулж, орчин үеийн технологиор тоноглох. Халимагийн “Жангар” портал шиг интерактив, виртуал боломжуудыг нэмэх

- Жил бүр Говь-Алтай, Ховд аймагт “Жангарын наадам” зохион байгуулж, туульсын тоглолт, уралдаан, үзэсгэлэн худалдааг зохион байгуулах

- Жангарын дүр, түүх дээр үндэслэн бүтээгдэхүүн (хувцас, дагалдах хэрэгсэл, гэр ахуйн эдлэл, дурсгалын зүйлс) үйлдвэрлэх жижиг, дунд бизнесийг дэмжих

- Жангарын анимейшн цуврал, баримтат кино, уран сайхны кино бүтээх ажлыг дэмжиж, залуу уран бүтээлчдэд зориулсан тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх

11.4. Дижитал хөгжлийн түвшинд

- Жангарын тоон мэдээллийн сан байгуулж, бүх материалыг цахим хэлбэрт шилжүүлэх. Энэхүү цахим сан нь судлаачид, оюутнууд, сонирхогчдод нээлттэй, хайлтын системтэй, хэрэглэхэд хялбар байх

- Хүүхдэд зориулсан Жангарын сургалтын аппликейшн, тоглоом хөгжүүлэх. Жангар туулийн сэдэвт цахим тоглоом, виртуал бодит байдлын бүтээгдэхүүн бүтээх

- Жангарын подкаст, аудио ном бэлтгэж, олон платформд түгээх

- YouTube суваг нээж, Жангарын тоглолт, илтгэл, сургалтын материалыг байршуулах

11.5. Соёлын аялал жуулчлалын түвшинд

- Жангар туульд дүрслэгдсэн газруудаар аялах тусгай маршрутууд бий болгох. Жишээлбэл, Жангарын домогт өлгий нутаг гэж тооцогддог газрууд, туулийн баатруудын нэрэмжит газруудаар аялах хөтөлбөрүүд

- “Жангар” наадмыг жил бүр зохион байгуулж, олон улсын жуулчдыг татах. Энэхүү наадмын үеэр туулчдын тэмцээн, туульд дүрслэгдсэн баатруудын хувцас өмсгөлтэй жагсаал, үндэсний спорт наадам, үндэсний хоолны үзэсгэлэн зэрэг олон төрлийн арга хэмжээ зохион байгуулах

- Жангар туулийн дуулалтыг үзүүлэх тусгай хөтөлбөрүүд, жангарчдын мастер-класс, үндэсний хоол, хувцас, зан заншилтай танилцах боломжуудыг санал болгох.

11.6. Олон улсын хамтын ажиллагааны түвшинд

- Халимаг, Хятадын Шинжаан, Оросын Халимаг зэрэг Жангар тууль хадгалагдан үлдсэн бүс нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх

- Эрдэмтэн солилцоо, хамтарсан судалгаа, эрдэм шинжилгээний хурлууд тогтмол зохион байгуулах

- Жангар туулийн хувилбаруудыг харьцуулан судлах олон улсын төсөл хэрэгжүүлэх

- Туулийг олон хэлээр орчуулах ажлыг эрчимжүүлэх

- Хятад, Монгол, Орос хамтран Жангарыг ЮНЕСКО-д бүртгүүлэх.

11.7. Халимаг, Хятад, Монгол улсын Жангар туулийг хөгжүүлэх туршлагын харьцуулалт

**Халимаг, Хятад, Монгол улсын
Жангар туулийг хөгжүүлэх туршилагын харьцуулалт**

Үзүүлэлт	Халимаг (ОХУ)	Хятад	Монгол
Төрийн бодлого	“Жангар” 2021-2025 оны улсын хөтөлбөр	“Хос бүтээл” бодлого, 2006 оноос үндэсний биет бус соёлын өвд бүртгэсэн	“Монгол баатарлаг туульс дэмжих тухай” зарлиг (2019), албан ёсны хөтөлбөр байхгүй
Судлалын төв	Халимагийн Хүмүүнлэгийн ухааны хүрээлэнгийн Жангар судлалын төв (А.Ш. Кичиковын нэрэмжит)	Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Үндэстний Уран Зохиолын Хүрээлэн	ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн (одоогоор тусгай төвгүй)
Туульч бэлтгэл	Ээлэн Овла, Шавалин Дава сургуулиуд, уламжлалт ба орчин үеийн аргуудыг хослуулсан	Жангарчдыг бэлтгэх хөтөлбөрүүд, сургуулийн хөтөлбөрт тусгасан	Жангарчдын сургууль байхгүй. Ховд, Увсад тууль зааж байгаа ч нэгдсэн тогтолцоо, арга зүй хангалтгүй
Дижитал хөгжил	“Жангар” портал, дижитал архив, текстийн корпус	Жангарын тоон мэдээллийн сан, виртуал музей, аппликейшн, тоглоом	Хязгаарлагдмал, нэгдсэн цахим сан байхгүй
Аялал жуулчлал	“Жангариада” наадам, Бумба орны аялал, тусгай маршрутууд	Ховогсайр хошууны “Жангарын өлгий нутаг” брэнд, Жангарын музей, соёлын ордон, наадам	Говь-Алтай, Ховд аймгийн “Жангарын наадам”, тогтвортой байдал, хүртээмж хангалтгүй
Олон улсын хамтын ажиллагаа	Олон улсын Жангар судлалын төв, эрдэм шинжилгээний хурал, англи орчуулга (Bougdaeva, 2022)	Олон улсын форум, Унгар, Орос, Монгол, Кыргызстан эрдэмтэдтэй хамтын ажиллагаа	Олон улсын хурлууд, гэхдээ тогтмол бус, хамтын ажиллагаа хязгаарлагдмал

Хүснэгтээс үзэхэд Халимаг улс төрийн бодлого, судлалын төв, туульч бэлтгэлийн тогтолцоо, дижитал хөгжил, аялал жуулчлал, олон улсын хамтын ажиллагаа зэрэг олон чиглэлээр тогтвортой, системтэй бодлого хэрэгжүүлж байна. Харин Монгол Улс эдгээр чиглэлээр тогтолцоо, санхүүжилт, урт хугацааны бодлогын хувьд харьцангуй сул байгаа нь анхаарал татаж байна.

Н о м з ү й

Бадмаева, Г. Г. (2018). Зөвлөлтийн дараах үеийн Халимаг улсын түүх, соёлын өвийг хадгалах соёлын бодлогын үндсэн чиглэлүүд. *Кавказын шинжлэх ухааны бодол*, 14(3), 112–120.

Бадма-Халгаева, О., Пичугина, В. (2020). Баатарлаг Жангар тууль нь Халимаг ардын мэргэн ухааны антологи: орос орчуулга ба сурган хүмүүжүүлэх агуулга. *ПСТГУ-ийн мэдээ*, 59, 91–104.

Биткеева, А. Н., Селеева, Ц. Б. (2019). “Жангар” тууль дижитал орон зайд: Халимаг ардын аман зохиолын өвийг хадгалах ба дамжуулах. *Дорно дахины судлал*, 12(3), 456–468.

Борлыкова, Б. Х. (2018). Халимаг дахь Жангарчлах уламжлал: Ээлэн Овла ба Шавалин Дава сургуулиуд. *Ардын аман зохиол судлал*, 7(2), 45–58.

Дорджиева, Г. С. (2021). Халимагийн баатарлаг “Жангар” туулийг хадгалах ба сурталчлах орчин үеийн технологиуд. *РАН-ийн Халимагийн Хүмүүнлэгийн ухааны хүрээлэнгийн мэдээ*, 14(2), 234–245.

Дякиева, Б. Б. (2017). Кичиков Анатолий Шалхакович (1921-1998): “Жангар” туулийг дэлхийд нээсэн эрдэмтэн. *LIBRI MAGISTRI*, 5(2), 78–89.

Иванов, А. А. (2022). “Жангариада” нь Халимагт угсаатны соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүчин зүйл болох нь. *Үйлчилгээ ба аялал жуулчлал: Инноваци, технологи, тогтвортой байдал*, 16(1), 78–89.

Кичиков, А. Ш. (1997). *Халимагийн баатарлаг тууль “Жангар”*. Элиста: Халимагийн номын хэвлэл.

Манжиева, Б. Б. (2015). Халимагийн театрын урлаг дахь “Жангар” туулийн дүрслэл. *Урлаг судлал*, 12(3), 67–79.

Манжиева, Б. Б. (2023). Халимагийн “Жангар” тууль дахь Бумба орны дүрслэл ба орчин үеийн аялал жуулчлалын маршрутуудад түүний тусгал. *Газар зүй ба аялал жуулчлал*, 11(2), 112–124.

Сангаджиева, Н. С. (2020). Халимагийн боловсролын системд “Жангар” туулийг заах арга зүй. *Сурган хүмүүжүүлэх ухаан*, 15(4), 89–102.

Убушиева, Д. В. (2021). “Жангар” портал нь Халимагийн туульсын өвийг хадгалах, түгээхэд гүйцэтгэх үүрэг. *Оросын мэдээллийн нөөц*, 18(5), 34–42.

Халимагийн Бүгд Найрамдах Улсын Засгийн газар. (2020). *”Жангар” туулийг хадгалах, судлах, түгээх 2021-2025 оны улсын хөтөлбөр*. Элиста: Халимагийн Засгийн газар.

Bougdaeva, S. (Trans.). (2022). *Jangar: The Heroic Epic of the Kalmyk Nomads*. Oakland, California: University of California Press.

International Academic Conference on “The Epic of Jangar and Jangar Studies” Held in Honor of Scholar U. Zagdsuren. (2024). *Montsame*, March 15, 2024.

Omakaeva, E. U. [et al.] (2019). “Jangar” heroic epic in the mirror of the language, culture, and information technology: thematic dictionary. Социальные и культурные трансформации в контексте современного глобализма: сборник научных трудов II Международной научной конференции, посвященной 85-летию профессора Х.И. Ибрагимова, Грозный, 14–15 июня 2019 года. Vol. 3. Грозный: СибИздатСервис. 818–821.

Omakaeva, E. U. [et al.] (2025). Kalmyk Heroic Epic “Jangar” in the Original and Translation as a Bilingual Phenomenon: Thesaurus Modeling of Epic Lexicon and Translation Strategies. *Forum for Linguistic Studies*. Vol. 7, No. 2. DOI 10.30564/fls.v7i2.7878.

References

Badmaeva, G. G. (2018). Zövlöltijn daraax yeijn Xalimag ulsy'n tүүх, soyoly'n өvijg xadgalax soyoly'n bodlogy'n yndse'n chigle'lyyd. Kavkazy'n shinzhle'x ухааны' bodol, 14(3), 112–120 (in Russian).

Badma-Xalgaeва, O., Pichugina, V. (2020). Baatarlag Zhangar tuul' n' Xalimag ardy'n me'rge'n ухааны' antologi: oros orchuulga ba surgan хүмүүжүүлэх aguulga. PSTGU-ijn me'de'e', 59, 91–104 (in Russian).

Bitkeeva, A. N., Seleeва, Cz. B. (2019). “Zhanger” tuul' dizhital oron zajd: Xalimag ardy'n aman zoxioly'n өvijg xadgalax ba damzhuulax. Dorno daxiny' sudlal, 12(3), 456–468 (in Russian).

Borly'kova, B. X. (2018). Xalimag dax' Zhangarchlax ulamzhla: E'e'lon Ovla ba Shavalin Dava surguuliud. Ardy'n aman zoxiol sudlal, 7(2), 45–58.

Dordzhieva, G. S. (2021). Xalimagijn baatarlag “Zhangar” tuulijg xadgalax ba surtalchlax orchin yeijn texnologiuud. RAN-ijn Xalimagijn Xymyynle'gijn uxaany' xyre'e'le'ngijn me'de'e', 14(2), 234–245 (in Russian).

Dyakieva, B. B. (2017). Kichikov Anatolij Shalxakovich (1921-1998): “Zhangar” tuulijg de'lxijd ne'e'se'n e'rde'mte'n. LIBRI MAGISTRI, 5(2), 78–89 (in Russian).

Ivanov, A. A. (2022). “Zhangariada” n' Xalimagt ugsaatny' soyoly'n ayalal zhuulchlaly'g xogzhyye'x xychin zyjl bolox n'. Yjlchilge'e' ba ayalal zhuulchlal: Innovaci, texnologi, togtvortoj bajdal, 16(1), 78–89 (in Russian).

Kichikov, A. Sh. (1997). Xalimagijn baatarlag tuul' “Zhangar”. E'lista: Xalimagijn nomy'n xe'vle'l.

Manzhieva, B. B. (2015). Xalimagijn teatry'n urlag dax' “Zhangar” tuulijn dyrsle'l. Urlag sudlal, 12(3), 67–79 (in Russian).

Manzhieva, B. B. (2023). Xalimagijn “Zhangar” tuul' dax' Bumba orny' dyrsle'l ba orchin yeijn ayalal zhuulchlaly'n marshrutuudad tyynij tusgal. Gazar zyj ba ayalal zhuulchlal, 11(2), 112–124 (in Russian).

Sangadzhieva, N. S. (2020). Xalimagijn bolovsroly'n sistemd “Zhangar” tuulijg zaax arga zyjl. Surgan xymyzyhyyle'x uxaan, 15(4), 89–102 (in Russian).

Ubushieva, D. V. (2021). “Zhangar” portal n' Xalimagijn tuul'sy'n ovijg xadgalax, tyge'e'xe'd gyjce'tge'x yyre'g. Orosy'n me'de'e'ljij noecz, 18(5), 34–42 (in Russian).

Xalimagijn Bygd Najramdax Ulsy'n Zasgijn gazar. (2020). *”Zhangar” tuulijg xadgalax, sudlax, tyge'e'x 2021-2025 ony' ulsy'n xetelber*. E'lista: Xalimagijn Zasgijn gazar.

Bougdaeva, S. (Trans.). (2022). Jangar: The Heroic Epic of the Kalmyk Nomads. Oakland, California: University of California Press.

International Academic Conference on “The Epic of Jangar and Jangar Studies” Held in Honor of Scholar U. Zagdsuren. (2024). Montsame, March 15, 2024.

Omakaeva, E. U. [et al.] (2019). Jangar heroic epic in the mirror of the language, culture, and information technology: thematic dictionary. Social'ny'e i kul'turny'e transformacii v kontekste sovremennogo globalizma: sbornik nauchny'x trudov II Mezhdunarodnoj nauchnoj konferencii, posvyashhennoj 85-letiyu professora X.I. Ibragimova, Grozny'j, 14–15 iyunya 2019 goda. Vol. 3. Grozny'j: SibIzdatServis. 818–821.

Omakaeva, E. U. [et al.] (2025). Kalmyk Heroic Epic “Jangar” in the Original and Translation as a Bilingual Phenomenon: Thesaurus Modeling of Epic Lexicon and Translation Strategies. Forum for Linguistic Studies. Vol. 7, No. 2. DOI 10.30564/fls.v7i2.7878.